ХАВСРАЛТ №1

БАТЛАВ
"МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/ О.БАТЧУЛУУН /

БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

Төслийн нэр: Өмнөговь аймгийн Цогтцэций, Манлай болон Дорноговь аймгийн Мандах, Сайхандулаан, Сайншанд сумын Зүүнбаян багийн нутагт Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км төмөр замын тээврийн үйл ажиллагаа

Ажлын зорилго: Энэхүү ажлын зорилго нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хэрэгжилтийг хангуулах, төслийн байгаль орчны баримт бичгийг бүрдүүлэхэд орших бөгөөд зорилгоо хангахын тулд дараах зорилтуудыг тавьж байна. Үүнд:

- Төслийн үйл ажиллагаанд байгаль орчны төлөв байдлын үнэлгээ (БОТБҮ) хийх, тайлан боловсруулах.
- ЕҮД-ийн чиглэлд заасны дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ) хийж, БОЖАӨЯамаар баталгаажуулах

1. Хамрах хүрээ

1.1. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, БОТБҮ

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгэм, эдийн засгийн

өнөөгийн төлөв байдал болон төслийн замын ашиглалтаас орон нутгийн дэд бүтэц, нийгэм-эдийн засагт оруулсан ач холбогдлыг тодорхойлно. Үүнд:

-Газарзүйн нөхцөл
-Геологийн тогтоц
-Уур амьсгал
-Агаарын чанар
-Усан орчин
-Хөрс
-Ургамал
-Амьтны аймаг, амьдрах орчин
-Нутгийн иргэд, оршин суугчдын нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, эрүүл мэнд

-Түүх, соёлын өв зэрэг багтана.

2.2. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ

Төслийн замын ашиглалтаас байгаль орчин, нийгэм, оршин суугчдын ахуй, амьдрал, эрүүл мэндэд учруулж болзошгүй нөлөөллийг тодорхойлж,нөлөөлөл хуримтлах нөхцөлийг илрүүлэн үнэлнэ. Төмөр замын ашиглалтын үеийн байгаль орчны болон ажлын байрны сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх, зайлсхийх, бууруулах, хамгаалах арга хэмжээг зөвлөмж, хяналт мониторингийн хамгийн оновчтой хувилбарыг санал болгоно.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд төслийн төмөр замын ашиглалт, тээвэрлэлт хийхтэй холбогдох дараах бүхий л үйл ажиллагааг хамруулна. Үүнд:

-төмөр замын шугаман дээд, доод бүтэц
-гүүр, хоолой
-Өртөө, зөрлөг
-Эрчим хүч
-Усан хангамж
-Дохиолол холбоо, мэдээллийн барилга байгууламж
-Гарам, хориг хашаа
-Депо
-Гаалийн хяналтын талбай
-Ажилчдын орон сууц багтана.

2.3. Байгаль орчны менежментийн 5 жилийн төлөвлөгөө

Төслийн төмөр замын ашиглалтын үед байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөх ба түүнчлэн төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянаж, сөрөг нөлөөллийн динамик өөрчлөлт, хуримтлалын шалтгааныг илрүүлэхэд хяналт-шинжилгээний арга хэмжээний төлөвлөлтийг хийж, мониторингийн хатуу цэгүүдийн байршлыг тогтоож өгнө.

2. Хийгдэх ажлууд

- Төслийн төмөр замыг бүтээн байгуулалтаас ашиглалтад шилжүүлэх явц дахь байгаль орчны нөлөөллийн өөрчлөлт, хувьсал-цаашдын хандлагыг тодорхойлон үнэлэх
- Хээрийн судалгаа хийж, бүтээн байгуулалтаас ашиглалтад шилжих үеийн нөлөөллийн цар хүрээний өөрчлөлтийг тодорхойлон зураглах, хэмжилт судалгааны үр дүнгээр нотлон баримтжуулах
- Хээрийн судалгаа болон суурь судалгааг төслийн байгаль орчны үнэлгээ судалгааны өмнөх үеийн баримт бичигтэй харьцуулан жишиглэх
- Өмнөх үеийн судалгаа, үнэлгээнээс хойших хугацаанд өөрчлөгдсөн эрх зүйн орчинд үнэлгээ хийж дүгнэлт гаргах

- Төслийн төмөр замын ашиглалтын явц дахь олон нийтийн оролцоог үнэлж, оролцогч талуудыг шинэчлэн тодорхойлох, оролцогч талуудад чиглэсэн зөвлөмж өгөх
- Нөлөөллийн үнэлгээнд шинжлэх ухааны олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн судалгааны арга зүйг ашиглах ба болзошгүй болон гол сөрөг нөлөөллийн тархалт, үр дагаврыг тооцоолсон тооцоолол, зураглал, аргачлалыг ашиглана.
- Сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээний зөвлөмж боловсруулна. Зөвлөмж нь оновчтой, тодорхой, төслийн онцлогт нийцсэн бөгөөд практикт хэрэгжүүлэх боломжтой байхаар төлөвлөсөн байна.
- Зам барилгын бүтээн байгуулалтын үеийн осол, эрсдэлийн нөхцөлийг судалж үнэлэн, холбогдох зөвлөмжийг боловсруулна.
- Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг албан ёсоор танилцуулж захиалагчаас санал авна.
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт хамаарах багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлж, хурлаас гарсан шийдвэр, тэмдэглэлийг хавсаргах зэрэг ажлыг зайлшгүй хийсэн байна.

3. Үр дүн
   - Байгаль орчны төлөв байдлын үнэлгээгээр төслийн төмөр замын зурвас нутгийн дагуу төмөр замын ашиглалтын үеийн байгаль орчин, нийгмийн одоогийн байдлыг төслийн хэрэгжилтийн оролцоотойгоор үнэлсэн байх.
   - Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулан байгаль орчны мэдээллийн санд олон нийтэд ил байдлаар байршуулсан байх.

4. Баримт бичгийн боловсруулалтад баримтлах эрх зүйн баримт бичиг
   - Байгаль орчныг хамгаалах тухай хууль
   - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
   - “Журам батлах тухай” 2023 оны Засгийн газрын А/58 дугаар тогтоол
   - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
   - Байгаль орчин болон хөдөлмөр хамгааллын холбогдох бусад хууль, журам, дүрэм, норм, стандарт

5. Гүйцэтгэгчид тавигдах шаардлага:
   - Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл бүхий эрх бүхий мэргэжлийн байгууллага байх ба даалгаварт ажил гүйцэтгэхэд шаардлагатай техник хэрэгсэл, багаж

хэрэгсэл, тоног төхөөрөмж, программ хангамжтай, мэргэжлийн баг бүрдүүлсэн, мэргэшсэн хүний нөөцтэй байна.

- Мэргэжлийн байгууллага нь холбогдох тусгай зөвшөөрлөөр 5-с доошгүй жил ажиллагаа явуулсан байх ба хуульд заасанчлан байгаль орчны нөлөөллийн үнэлгээний зэрэгцээ өөр үйл ажиллагаа эрхэлдэггүй байх ба ижил төстэй ажлын 2-с доошгүй туршлагатай байх.
- Мэргэжлийн байгууллагын ажил гүйцэтгэх мэргэжлийн багийн 40 хүртэл хувь нь тухайн мэргэжлийн байгууллагын үндсэн ажилтан байх ба үндсэн ажилтны дотор нийгмийн нөлөөллийн судалгаа болон үерийн далан, гидротехникийн мэргэжилтэнтэй байх, судалгааны багт нь төслийн бүс нутагт судалгаа хийж байсан мэргэжилтэн оролцож байвал давуу тал болно.
- Судалгааны багийн ахлагч нь байгаль орчны үнэлгээний салбарт 10-с доошгүй жил ажилласан байх ба төмөр замын болон авто замын төслүүдийн БОННҮ-нд оролцсон байх.

6. Гүйцэтгэгчийн хүлээх үүрэг
   - Ажлыг мэргэжлийн түвшинд хийх ур чадвартай, тогтвортой үйл ажиллагаа явуулж, захиалагч талд хуульд нийцсэн зөвлөмжүүдийг өгч ажиллана.
   - Гүйцэтгэгч нь тайланд тусгасан мэдээ, мэдээллийн үнэн зөвийг бүрэн хариуцах ба өгсөн зөвлөмжүүд нь амьдралд нийцтэй, хэрэгжих боломжтойгоос гадна зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх дарааллыг тодорхойлсон байх шаардлагатай.
   - Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэхтэй холбоотой нууцад хамаарах мэдээллийг задруулахгүй байх талаар баталгаа гаргаж, нууцын гэрээ хийнэ.
   - Батлагдсан тайлан, төлөвлөгөөг цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүлээлгэн өгөх ба хэвлэмэл тайлан нь харьяа газруудыг тооцсон байна.

ЗӨВШӨӨРСӨН:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Д.БАТНАСАН

ХЯНАСАН:

ХАБЭА, БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЭЛТСИЙН ДАРГА – бш Э.ХАТАНБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН Ш.АЛТАНГЭРЭЛ